

## МОНГОЛЧУУДЫН ШАШИН-СОЁЛЫН ОНЦЛОГ БАЙДАЛ: УЛАМЖЛАЛ БА ШИНЭЧЛЭЛ

М.Гантуяа /доктор (Ph.D), профессор/

Т.Булган /доктор (Ph.D)/

С.Дэмбэрэл /докторант/

МУИС, Философи, шашин судлалын тэнхим

**Түлхүүр үг:** Шашин, соёл, сэтгэлгээ, бөө мөргөл, анимизм, буддизм, христийн шашин, ислам, монголчуудын уламжлалт шашин, орчин үеийн шашин судлал, шашины нэгдмэл байдал, шашины задрал, плюрализм, эв нэгдэл, даяаришил, үндэсний соёл, үндэсний ухамсар

**Товч утга:** Монголчуудын амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэл, амьдрах ухаан, шашин шүтлэг нь нүүдлийн соёл иргэншлийн онцлог байдлыг илэрхийлдэг. Тэдний шашин соёлын онцлог байдлыг түүхэн он дарааллын үүднээс авч үзвэл эртний буюу дундад эртний үед тэдний оюун санааны амьдралд мөнх тэнгэр, байгаль дэлхий, өвөг дээдсээ дээдлэн шүтэх бөө мөргөл зонхилж байсан бол, дундад зууны үе буюу дундад зууны хожуу үед буддын шашин хүчтэй нөлөөлж байжээ. Харин орчин үеийн даяарилын эринд Монголчуудын дунд буддын шашин зонхилох нөлөөтэй байгаа ч бөө мөргөл, христийн шашины янз бүрийн урсгал, ислам, шинэ шашины хөдөлгөөнүүд зэрэг олон янзын шашин дэлгэрч байна. Түүнтэй зэрэгцээд уламжлалт соёл, хувь хүмүүсийн болон нийгмийн амьдралын ахуй ёсонд өөрчлөлт шинэчлэл гарч байгааг цаашид судлаачид хамтран судалж тогтоох нь Монголчуудын шашин-соёлын онцлогийг дэлхий нийтийн даяарилын эрин үед хэрхэн хадгалж үлдэх, уламжлал ба шинэчлэлийн харилцааг хэрхэн зөв тогтоох асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй гэж үзэж байна.

Монголчууд нүүдлийн соёл иргэншлийг цогцлоон, түүнийг зайлшгүй дагалдах ахуй соёл, шашин номын ёсыг бүтээсэн нь тэдний өнөөг хүртэл хадгалж ирсэн томоохон соёлын уламжлал гэж хэлж болно.

Нүүдлийн соёл иргэншлийн суурийн соёл иргэншлээс ялгарах онцлогийн талаар гадаад, дотоодын судлаачид судалгаа бүтээлдээ тэмдэглэн хэлсэн нь цөөнгүй<sup>1</sup>.

<sup>1</sup> А.Ж. Тойнби. Түүхийг ухаарахуй. Хоёрдугаар хэсэг. Соёл иргэншлийн өсөлт. Хэсэгчлэл. Орчуулсан Ш.Ганхуяа // Эрх чөлөө ба философи. УБ 2000. №7. Х.30-33, А.Дж.Тойнби.

Нүүдлийн соёл иргэншилд суурин соёл иргэншлээс ялгарах хэд хэдэн онцлог байна. Үүнд:

1. Байгалийн онгон зэрлэг хөрс, зэрлэг ургамлыг сонгон малаа бэлчээж өсгөн, мах сүү, арьс шир, ноос ноолуур зэрэг малын бүх бүтээгдэхүүнийг ахуй амьдралдаа ашиглах замаар өөрийн гэсэн өвөрмөц соёлын хэв маягийг бүтээдэг.

Постижение истории. М 1991. С. 181-186, Лев Гумилев. Этногенез и биосфера Земли. М.-Л., 1979. Звено между природой и обществом. Н.Хавх. Монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн гүн ухаан. УБ 2005

2. Өвс ургамал, газар шороо, уул хад, ургамал мод бүхэн мал амьтны өсөж үржих гол эх үүсвэр нь мөн учраас байгалийг бүхний эх, ээж хэмээн дээдлэн шүтэж, байгалийн онгон зэрлэг байдлыг алдагдуулахгүйгээр мал ахуйгаа хөтлөн, амьдрал соёлоо бүтээн босгодог.

3. Онгон зэрлэг уул хангай, тал хээрийн түмэн зүйлийн ургамал, ус рашаанаар ундаалж хооллосон бэлчээрийн малын бүтээгдэхүүн нь шим тэжээлээр баялаг, цэвэр органик найрлагатай байх тул хүний биед ээлтэй, хор нөлөөгүй, байгальдаа зохицсон байдаг.

4. Монгол хүнийг тэжээж, өсгөж, үржүүлж, хооллож, хувцаслаж, орон байр, эдлэл хэрэглэлээр хангаж байдаг гол эх үүсвэр нь мал учраас малыг дээдлэн, маллах, бүтээгдэхүүнийг нь ашиглах үйл ажиллагаагаа амьд байгалийн хуулинд зохицуулан нарийн зохион байгуулдаг.

5. Нүүдлийн мал аж ахуй, амьдрал соёлын хүрээнд монгол хүмүүст ургамал судлал, амьтан судлал, байгаль орчин судлал, нар, сар, од, эрхсийн хөдөлгөөн, орон зай, цаг хугацааны баримжаа, цаг агаар, уур амьсгалын гэх мэт олон талт мэдлэг чадвар зохилдон бүрэлдэж, хийсвэр мэдлэг ба практик үйл ажиллагааны амьд хэлхээ холбоо тогтдог.

Хэрвээ суурин соёл иргэншилт ард түмнүүдийн хувьд хүмүүсийн оюун ухаан, хөдөлмөр хүчээр бүтээгдсэн соёлын үнэт зүйлсийг нандигнан хамгаалж ирсэн байдаг бол нүүдлийн соёл иргэншилт, монголчуудын хувьд байгалийг онгон зэрлэгтөрхөөр нь хадгалан хамгаалах явдал хамгийн чухал үнэт зүйлд тооцогддог.

Монголчууд байгаль дээрхи бүхий л юмс үзэгдлийг амьтай, эзэнтэй, сахиустай гэж туйлаас эмзэглэн нандигнаж ирсэн түүхтэй<sup>2</sup>. Хэдийгээр энэ нь эртний маги, фетиш, тотем шүтлэг, анимизмтай холбоотой ч, нүүдлийн мал аж ахуйгаараа дамжин байгальтай шууд ойр харьцаж ирсний хувьд байгалийн араншин, өөрчлөлт хувирал нь хүмүүсийн байгальд хандах хандлагаас ихэд шалтгаалдаг болохыг балар эрт үеэс мэдэрч, мэдэж ирсний үр дүн болно.

Байгалийн түмэн янзын юмс үзэгдэлд хандаж байгаа хүний хандлага, хүний сэтгэлээс хамааран эргээд хүмүүст нөлөөлөх нөлөөлөл нь шалтгаалдаг хэмээх монголчуудын үзэлд хүмүүсийн сэтгэлийн чадал чансааг өндөрт үнэлсэн мэдлэг мэдрэмж хадгалагдан байна. Монголчуудын энэ үзлийг, байгальтай та яаж харьцана, байгаль танд тэгэж л хандана гэсэн үгээр тайлбарлаж болох юм.

Ийнхүү манай ард түмэн нь балар эрт цагаас өдгөө хүртэл тэнгэрийн нар, сар, од, гарагийг газрын хөрс, шороо, уул, ус, ургамал, амьтантай нь хамт цогцоор нь ухааран ойлгож, дээдлэн хүндэлж, шүтэн биширч ирсэн түүх уламжлалтай, амьдралын бүхий л хүрээндээ өөрийн гэсэн ёс заншил, туршлага дадлага, мэдлэг соёлоо уламжлуулан хэрэглэж чадсан, дээдэс өвгөдийнхөө сургаал болгон үеэс үед дамжуулан өгүүлж, гэрээслэл

<sup>2</sup> ШУТИС-ийн антропологи-археологийн багш, Др., Проф. Ю.Болдбаатар: "Сүглэлийн асуудал" //Философи, соёл судлалын тулгамдсан асуудал" ШУТИС-ийн 35 жилийн ойд зориулсан ЭШХ-ын материал, 2004, х.196-210, "Буган хөшөөн дэх бугын дуудлага: Өвгөдийн онгод даллахуй" //Соёл судлаачдын үндэсний семинар, х.152-158, Улаанбаатар, 2010, "Монголын эртний нүүдэлчдийн тэнгэр шүтлэгийг судлах нэгэн чухал чиглэл болох задын шүтлэг" // Монголч эрдэмтдийн х их хурлын илтгэлүүд – iii/, х.12-118, 2012

болгож өвлүүлсэн эрхэм нандин зүйлсээ тогтношуулж хэвшүүлж чадсан ард түмэн билээ.

Бидэнд ёс заншлын, цээр хорионы, сургаал сургамжийн арвин их өв бий. Олон янзын хорио цээрийн ёсны дотроос байгаль орчин, ялангуяа ундны эх ундарга - булаг цөөрөм, рашаан усаа хайрлан хамгаалах монгол ёс заншлаа хадгалан үлдээж, хэвшүүлэн мөрдүүлэх асуудал нэн чухал болоод байна. Ус рашаантай холбоотой ихэнх хорио цээрийн ёсонд монголчуудын ус рашааны эзэн сахиус болох Лусыг шүтэх үзэл бишрэл агуулагддаг байна. Лус савдагийн тухай монгол ойлголт бол угтаа байгалийн юмс үзэгдэл, рашаан усыг амьтай хэмээн итгэх амьчлах үзэл билээ.

Үнэндээ хүн төрөлхтөн байгалийг амьгүй, ургамал – амьтан - хүнийг амьтай хэмээн “амьгүй ба амьд байгалийн тухай” ялгаатай үзлийг гаргаж, “байгалийн ухаан ба хүмүүнлэгийн ухаан” хэмээн ялгаатай хоёр үндсэн шинжлэх ухааныг хөгжүүлж ирсэн ч, “тэнгэр огторгуй – дэлхий ертөнц – хүн амьтан” хэмээх гурвалыг нэгдмэл цогц байдлаар ухаарч, тэр л билиг ухаанаараа байгальд хандаж, байгальтай харьцаж, байгалийг амьдралын эх булаг, үндэс язгуур хэмээн хүндлэн биширч ирсэн монгол билиг ухаан эх дэлхий, газар шороо, ус ундрага руугаа хэзээ ч мэсний үзүүр, гарын хир оруулж байгаагүй, атга шороо, балга усныхаа төлөө амь биеэ зориулан тэмцэж ирсэн монгол өвөг дээдсийнхээ ариун сургаал, нандин сэтгэл зүрхийг өнөөдөр нэхэн ойлгох хэрэгтэй болж байна.

Бүлээн хошуут малаа хайрлан өсгөж,

хариулан хамгаалж, хүний хэрэглэдэг бүхий л хэрэгцээний зүйлсийг малаасаа гарган боловсруулж ирсэн монгол мэдлэг ухаан нь малаараа дамжуулж хүн-байгалийн нэгдмэл цогц мөн чанарыг танин мэдэж, байгаль дээр тусдаа салангид нэг ч зүйл байдаггүйг ухаарч, бүхнийг нэгэн бүхэл бие цогцос гэж үзэж хандаж ирсэн түүхтэй.

Чулуу бүхний цаана ус рашаан бий гэдгийг, булаг шанд бүхний цаана ургамал ногоо бий гэдгийг, хөрс шороо бүхний цаана амьдрал цэцэглэнэ гэдгийг, газрын доорхи эрдэнэс нь хөрсөн дээрх амьдралын үндэс суурь мөн гэдгийг хэнээс ч дутахгүй ухаарч, байгаль эхээ хайрлах үзлээр чулуу бүхнийг нандигнаж, шороо бүхнийг эрхэмлэж, усны дусал бүхнийг хамгаалж байсан эртний монгол ухаан монголчуудын зүрх сэтгэлд хадгалагдан үлдсэн болой. Огторгуйгаас хур бороо, ус рашаанаас чийг дулаан, хөрс чулуунаас ургамал ногоо, цэцэг жимснээс адгуус амьтан, мал ахуйгаасаа монгол хүн, бидний өвөг дээдэс, эцэг эх, бид өөрсдөө, бас бидний үр хойч амь амьдралаа авдаг гэдгийг, тэгэхээр амьд явахын үндэс нь байгаль дэлхий, мал амьтан, газар шороо, чулуу эрдэнэс, ус рашаан гэхчлэн байгаль ертөнц – хүн нийгмийн амьдрал нэгэн бүхэл цогц зүйл гэж үзэх нь удам монголын ертөнцийг үзэх үзлийн үндэс гэж хэлж болно<sup>3</sup>. Монголчуудын байгаль дэлхийгээ хайрлах үзэл нь эртний бөө мөргөлтэй салшгүй холбоотой.

<sup>3</sup>Б.Гантөмөр, М.Гантуяа. Байгаль экологийн бодлого ба рашаан усны талаархи монгол цээр ёс //Философи, эрхзүйн боловсрол. МУБИС, ТНУС-ийн э.ш.бичиг. 2014/7.

Ер нь **монголчуудын бөө мөргөлийн** мөн чанар, зан үйлийн онцлог, гарал үүсэл, түүх эволюцийн асуудлыг үе үеийн судлаачид янз бүрийн өнцгөөс харилцан адилгүй тайлбарласан байдаг. Зөвхөн монголчуудын бөө мөргөлийн түүхийн үечлэлийн асуудалд л гэхэд 1990-ээд оноос өмнөх судлаачид буюу Монголын алдарт түүхч Ч.Далай эрт үеийн болон дундад зууны үеийн бөө мөргөл гэж ангилсан байхад, Хятадын судлаач эрдэмтэн Х.Буянбат 1985 онд хэвлүүлсэн “Монголын бөөгийн шашины учир” номондоо:

1. Эхийн эрхт овгийн байгууллын үеэс манай эриний VII зуун буюу Бөртэ чонын үе хүртэлх үе “Монголын бөөгийн шашины үүсэл үе”

2.VII зуунаас МУ-ын нэрийг Юань хэмээсэн 1271 он хүртэл Монгол Бөөгийн шашины хөгжил үе

3.1271 оноос Юань улс задарч Монголын улс төрийн төв эх нутагтаа эргэн ирсэн 1368 он хүртэлх үе. Монголын шашины буурал үе

4.1368 оноос шарын шашин Монголд ноёрхох болсон XVI зууны 70-аад он хүртэлх үе. Монголын бөөгийн шашины сэргэлтийн үе

5.XVI зууны 70-аад оноос XX зууны эхэн үе. Монгол бөөгийн шашины устгалын үе хэмээн таван үед авч үзжээ.

Гэтэл орчин үеийн монголын Бөө судлаач, гоц үзэгдэл далд ухамсар судлаач Б.Мөнхдалай<sup>4</sup>:

1. Бөө мөргөлийн үүсэл үе: Хүй

нэгдлийн үеэс – Овог аймаг үүсэх үе хүртэлх

2. Бөө мөргөлийн хөгжлийн үе: Овог аймгийн үүсэх үеэс – Анхны төрт улс байгуулагдан задрах хүртэлх үе МЭӨ 209 он

3. Бөө мөргөлийн задралын үе: Хүннү гүрэн задрах үеэс МЭ 48- Монголын анхны тулгар төр байгуулагдах үе (XIII зуун буюу 1206 он )

4.Бөө мөргөлийн мандан бадралын үе: Монголын анхны тулгар төр байгуулагдах үе (1206 он )- Монгол улсын нэрийг Юань хэмээсэн 1271 он хүртэлх үе

5. Бөө мөргөл буурах үе: Юань улс байгуулагдсан үеээс (XIII зуун буюу 1271 он)- Юань улсын төр мөхөж, Монголчууд Хятадын нутгаас хөөгдөн эх нутагтаа эргэн ирэх (XV зуун буюу 1368 он) хүртэлх үе.

6. Бөө мөргөл сэргэн дэлгэрэх үе: Юань улс задарч (1368 он) - Монголд шарын шашин дэлгэрэх үе хүртэл (1577он)

7. Бөө мөргөлийн доройтон буурах үе: Монголд шарын шашин дэлгэрэх үе (1577 он) – Манжийн эрхшээлд байх үе

8. Бөө мөргөл шинэчлэгдэн дэлгэрэх үе: Манжийн эрхшээлд байх үе (1800 он)– Их хэлмэгдүүлэлт эхлэх үе (1932)

9. Бөө мөргөл устан алга болох үе: Их хэлмэгдүүлэлтийн үеэс (1932)– Ардчилсан хувьсгал хийх хүртэлх үе (1990 он)

10. Бөө мөргөлийн шинэ сэргэн мандалтын үе: Ардчилсан хувьсгалын үеэс (1990 он) – Одоог хүртэлх үе гэсэн 10 үед хувааж үзсэн байна.

<sup>4</sup> Бөө судлаач, гоц үзэгдэл далд ухамсар судлаач Б.Мөнхдалай // [www.mongolchuudaa.com](http://www.mongolchuudaa.com)

Бөө мөргөлийг монголчууд байгаль эх дэлхийгээ хамгаалах, өвөг дээсийн ариун нандин өв соёлыг хадгалахад чухал үүрэгтэй гэж үзэхээс гадна “бөө мөргөлийн шашин бизнес рүү орж мөнгө олох хэрэгсэл болж хувирсанаар хаа холын алс бөглүү хязгаарт ч, хүн ам төвлөрсөн их хотын зах дээр ч “чанар нь” орж онгод нь заларсан бөө нар ухаан алдан унаж “мэндэлцгээх” болсон, эдүгээ бөө нар бөө нартайгаа эрэгчин эмэгчинээ үзэлцэх болсон”<sup>5</sup> гэх мэт шалтгаанаар шүүмжлэх өнгө аяс ч элбэг байна.

Монгол улсын 2010 оны хүн ам, орон сууцны тооллогоор хүн амын дунд бөө мөргөлийг дагагчдын тоо 2.9% болж өссөн байдаг.

2013-2014 онд МУИС-ийн Нийгмийн ухааны салбараас хэрэгжүүлсэн “XXI зууны Монголын нийгэм: хөгжил, өөрчлөлт, хандлага” сэдэвт социологийн судалгааны төсөлд МУИС-ийн Шашин судлалын салбарын баг хамтран оролцож монголчуудын шашин шүтлэг, сүсэг бишрэлийн яг энэ цаг үеийн төлөв байдал, чиг хандлагыг Улаанбаатар хот, төв, зүүн бүсийн 10 аймгийн 2610 хүний дунд явуулсан судалгааны дүнгээр Тэнгэр бөө шүтлэг харьцангуй өссөн хандлага ажиглагдаж байгааг дараахь хэдэн шалтгаанаар тайлбарлаж байна<sup>6</sup>.

- Монголчуудын үндэсний ухамсар, үндэсний уламжлалт соёлоо дээдлэх үзэл,

- XIII зууны үеийн Монголын хүчирхэг эзэнт гүрэн байгуулагдаж байсан

үеэ санагалзах үзэл санаа,

- Суурин соёл иргэншил болон дэлхийн даяаршлын эрин үетэй зэрэгцүүлэн нүүдлийн соёл иргэншил, түүнд тохирсон монгол ахуй амьдралаа сэргээх оролдлого ихэсч байгаатай холбон тайлбарлаж болох юм.

- Мөн нийгэм, эдийн засгийн шилжилтийн үед тулгарч буй бэрхшээлийг давж гарахын тулд өвөг дээдсийн онгон шүтээнд амьдрал, хувь заяагаа даатгах шалтгааны улмаас бөө мөргөл өссөн байдаг.

Нүүдлийн соёл иргэншилт монголчуудын нийгмийн амьдрал хэзээ ч хаалттай ертөнц байгаагүй бөгөөд анхны төрт улсаа байгуулсан цагаас буюу Хүннү гүрний үеээс дэлхийн бусад соёлт орнуудтай худалдаа-соёлын өргөн харилцааг хөгжүүлэх боломжийг тал бүрээс эрэн сурвалжилж ирсэн байдаг. Тухайлбал, хүннүчүүд тэр үеийн торгоны замын төв буюу Дундад Ази, бүр тодруулбал, Ли-ийн орон хэмээн монгол сурвалжуудад тэмдэглэн нэрлэсэн Тажикстанаар дамжин Энэтхэг, Египет, Грек, Италийн соёлтой эртнээс холбогдсон мэдээ баримтыг түүх-археологийн олдворууд улам бүр дэлгэн тавьсаар байна. XIII зуунд Ази-Европыг холбосон торгоны замын төвийг Хар-хорумд шилжүүлснээр монголчууд өрнө-дорнын соёлын их далайд сэлж, тэр хэрээр Монгол газраа гадны шашин-соёлын олон урсгал чиглэлүүд нэвтэрсэн байдаг. Ийнхүү монголчууд эртнээс хүн төрөлхтөний бий болгосон ертөнцийг үзэх үзэл номлол, шашин суртахууны олон янзын онол сургаал, тайлбар ухуулгатай нүүр тулж ирсэн ч тэдгээрийн дотроос

<sup>5</sup> Мөн тэнд

<sup>6</sup> М.Гантуяа. Өнөөгийн монголчуудын шашин шүтлэгийн төлөв байдал, чиг хандлага // *Philosophy, Religious studies*. 2015. Volume 17 (434). ISSN 2220-959X. х.132

монголын нүүдлийн соёл иргэншлийн уугуул үзэл санаа, байгаль ертөнцийг үзэх үзэлд зохицон нийлэх тийм үзэл баримтлалыг илүүтэй үзэж, өөрийн газар нутагтаа шингээн суулгаж, дэлгэрүүлэн хөгжүүлж ирсний тод жишээ нь Монголд дэлгэрсэн Буддын шашин-соёл юм. Монголд бурхан шашин дэлгэрсэн түүхийг эртнээс Монголын номын мэргэдүүд ном судартаа бичиж сийрүүлж үлдээсэн байдгийн алдартай жишээ нь Зава Дамдин гавжийн “Умар зүгийн их Монгол улс орны домгийн их шастир ухааныг баясгагч гайхамшигт Алтан дэвтэр”, Сүмбэ хамба Ишбалжирын “Энэтхэг, Хятад, Төвд, Монгол орноо дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёс Галбарвас модон”, Дармадала гүүшийн “Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч Цагаан лянхуан эрхис” зэрэг түүхийн зохиолыг нэрлэж болох юм. Дээр дурьдсан Төвд, Монгол сурвалж бичгүүдээс гадна эртний Хятадын түүх шаштирт тэмдэглэж үлдээсэн мэдээ сэлт нь их үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болно.

**Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн түүхээс:**

Түүхийн сурвалжуудад тэмдэглэснээр, Монголд бурхан шашин гурвантаа дэлгэрсэн гэдэг.

1) Хүннү гүрнээс Хядан гүрэн хүртлэх үед Энэтхэгээс шууд болон Дундад Азиар дамжин Бага, Их хөлгөний урсгалууд дэлгэрсэн үе буюу аргын тооллын өмнөх II зуунаас аргын тооллын XI зууныг хамрах бурханы шашины түрүү дэлгэрлийн үе (*т.ө II- XI-р зууны үе*)

2) Чингис хаанаас Тогоонтөмөр хаан

хүртлэх их хаадын үед Төвдийн сажава хийгээд гармавагийн чиглэлүүд дэлгэрсэн бурханы шашины дунд үеийн дэлгэрэлт (*XII-XV зуун*)

3) Богд Зонхавын шашин дэлгэрч хөгжсөн буюу XVI-XX зууны үеийг хамрах бурханы шашин дэргэрсэн гуравдугаар үе гэсэн өөр хоорондоо залгамж холбоо бүхий гурван үеийг хамаардаг (*XVII- XX зуун*).

Монголын анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар Зонхавын ёсыг дэлгэрүүлэхдээ Монгол орны цаг уур, зон олны онцлог байдалд зохицуулан лам нарын өмсгөл, уншлага хурлын дэг ёс, ая дан бүхнийг Монголын буддизм ихээхэн ялгарах өөрийн онцлог төрхтэй шашиныг үндэслэсэн билээ. Өндөр гэгээнтэй хамтран түүний шавь Зая бандида Лувсанпэрэнлэй, Ламын гэгээн Лувсанданзан, Чин сүсэгт номун хан Норовшэйрав, Дарба бандида Содовжамц нар өөр өөрийнхөө хошуу нутагт сүм хийд байгуулж хурал ном гаргацгаажээ.

*Монгол орны дэлгэрсэн буддын сургааль, гүн ухааны гол ойлголтууд болох арга билиг, шүтэн барилдлага, хамаг амьтаныг тэгш энэрэнгүй үзэх, дараа төрөл, хүч үл хэрэглэх үзэл санаа, үйлийн үрийн сургааль, хэрэгцээний хэрээр зохист хэрэглээг эрхэмлэх үзэл нь Монголчуудын байгалиа хамгаалах үзэлд чухал нөлөө үзүүлж ирсэн байдаг.*

**XX-XXI зууны монголчуудын шашин-соёлын байдал**

XX зууны дундуур монголчуудын дунд марксист үзэл суртал, шашингүйн үзэл өргөн дэлгэрсэн нь ертөнцийг үзэх

уламжлалт үзэл баримтлал алдагдахад хүргэсэн билээ. Хэдийгээр энэ үед монголчуудын дунд Оросоор дамжаад өрнийн соёл иргэншил, орчин цагийн шинжлэх ухааны мэдлэг боловсрол хөгжсөн нь нүүдэлчдийн хувьд соёлын том ололт гарцаагүй мөн боловч байгаль, цаг агаартай тохирсон ахуй соёлыг цогцлоож ирсэн уламжлал тасран, монголчуудын эртний мэдлэг ухаан алдагдах болсон юм.

1930-аад оны үе гэхэд халх 4 аймгийн 80 гаруй хошуунд нийт 1000 гаруй том жижиг хурал<sup>7</sup>, сүм хийд үйл ажиллагаагаа явуулж байсан байна. 1938 онд Монгол оронд их хэлмэгдүүлэлт эхэлж 20 гаруй мянган лам нар баривчлагдан тэднийг 3 анги болгон хувааж дээд анги буюу хэргэм зэрэг, мяндаг цолтой лам нарыг буудан хороож, дунд анги буюу идэр насны лам нарыг 10 хүртэл жилээр шоронд хорьж тарчилган зовоож байжээ. Доод анги буюу 20 хүртэл насны 30 000<sup>8</sup> орчим залуу лам нарыг энгийн ард болгон ард түмний шүтэн биширч байсан бурхан шүтээн, оюуны үнэт зүйлс, ном судар бүгдийг нь үгүй хийж 700 гаруй сүм хийдийг эвдлэн нураажээ. 1944 он хүртэл Бурханы шашин хөгжин мандаж байсан Монгол оронд энэ тухай сэдэв хаалттай болсон байна. Сайд нарын хурлын шийдвэрээр 1944 онд Гандан хийдийг хуралтай болгох талаар анхаарал тавьж эхэлсэн бөгөөд ингэхдээ бүх зүйлийг тухайн үеийн намын хатуу чанга хяналтын доор хийдийн үйл ажиллагаа явдаг байжээ.

Харин 1990 оны ардчилсан өөрчлөлт нь уламжлалт шашин-соёлоо сэргээх өргөн боломжийг нээснээр социализмын үед хаагдмал байсан соёлын олон түүх уламжлалаа дахин сэргээн хөгжүүлж байна.

Ялангуяа 70 гаруй жил хяналт, шалгалтын доор шүтэгдэж байсан Бурханы шашин мандан дэлгэрэх, сүсэгтэн олон бурхан шашинаа чөлөөтэй шүтэх бололцоотой болсон билээ. Энэхүү Монголчуудын оюун санаа, шашин шүтлэгийн эрх чөлөөний өөрчлөлтийг барууны буддын судлаач, зохиолч Глейн Мюллен<sup>9</sup> олон улсын төвд судлалын 13-р их хуралд тавьсан илтгэлдээ: *“Ардчилал Монголчуудад шашины эрх чөлөөг мөн авчирсан юм. Коммунизмийн үед Гандантэгчинлин хийд ганц зөвшөөрөлтэй хийд байсан бол ардчилал яснаар хүмүүс урьд байсан сүм хийдүүдийг дахин сэргээн барих болсон. Одоогоор Монголд ойролцоогоор 200 багахан хэмжээний сүм хийдүүд байна. Далан жилийн өмнө коммунистуудын устгасан сүм хийдүүдтэй харьцуулахад багахан боловч энэ нь бахархамаар эхлэл юм”*<sup>□</sup>.

Үүнээс гадна 1992 онд батлагдсан Монгол улсын үндсэн хуулиар шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуульчилж өгсөнөөр Буддын шашинаас гадна уламжлалт бөө мөргөл, исламын шашин, мөн орчин цагийн монголчуудын хувьд шинэ гэж хэлж болох христийн шашин болон бусад шашины байгууллагууд Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулах боллоо.

<sup>7</sup> С.Цэдэндамба. Монголын сүм хийдийн түүхэн товчоон. УБ, 2009, 16-р хуудас

<sup>8</sup> ШУА, Түүхийн хүрээлэн, Монгол улсын түүх, УБ, 2004, 5-р боть, 179-р хуудас

<sup>9</sup> [https://en.wikipedia.org/wiki/Glenn\\_H.\\_Mullin](https://en.wikipedia.org/wiki/Glenn_H._Mullin)

2010 оны хүн ам, орон сууцны тооллогоор Монголчуудын шашин шүтлэгийн байдлыг тодорхойлж гаргасан байдаг. Энэхүү тооллогоор Монголчуудын 61.4% нь шашин шүтдэг, 38.6% нь шашин шүтдэггүй гэсэн дүн гарсан бөгөөд нийт шашин шүтэгчдээс буддын шашиныг 53% нь, бөө мөргөлийг 2.9% нь, христийн шашиныг 2.1% нь, ислам шашиныг 3.0% нь, бусад шашиныг 0.4% нь шүтдэг хэмээжээ<sup>10</sup>. Эдгээр шашинаас монголчуудын түүх, соёл, ёс заншил, өдөр тутмын амьдралд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн бөө мөргөл, буддын шашинг уламжлалт шашин, Монгол орноо хожуу дэлгэрсэн христийн шашин болон бусад шашиныг уламжлалт бус шашин хэмээн судлаачид ангилсан байдаг. Өнөөдөр Монголд үйл ажиллагаа явуулж буй зарим шашины байгууллага, сүм цуглаанууд нь нийгэмд хандсан хүмүүнлэгийн сайн үйлсэд хувь нэмрээ оруулж байна. Мөн түүний хажуугаар шашины номлолоо зальжин аргаар дэлгэрүүлж, хүний тархи угаадаг, хувь хүний эрхийг зөрчдөг, улс орны түүх, соёл уламжлалыг гутаан доромжилдог, шашиныг бизнесийн болон улс төрийн зорилгоор ашигладаг, хүмүүсийг нийгмээс тусгаарлах чиг хандлагатай шашины гаж урсгалууд, шинэ шашины хөдөлгөөнүүд Монголын нийгэмд байр сууриа бэхжүүлэх үйл ажиллагааг идэвхтэй явуулж байгааг шашины байгууллагууд<sup>11</sup>, судлаачид болон олон нийтийн мэдээллийн байгууллагууд<sup>12</sup> шүүмжилж байна.

<sup>10</sup> Glein Mullin. Олон улсын Төвд судлалын XIII их хурал дээр тавьсан илтгэл <http://www.iats.info/panels-and-sessions/>

<sup>11</sup> <https://tuv.nso.mn/uploads/users/4/files/ХАОСТ%20улс.pdf>

<sup>12</sup> Монголын Эвангелийн Эвсэл, "Гаж буруу урсгалууд" танилцуулга, 2013, УБ

Монголчуудын дунд дэлгэрээд буй олон янзын шашиныг хувь хүн, нийгмийн амьдралд гүйцэтгэж байгаа үүрэг зориулалт, нөлөөллөөр нь ердийн ба ер бусын шашин<sup>13</sup>, зонхилох байр суурь эзэлж буй шашин, өрсөлдөгч, хувьсган өөрчлөгч шашин гэсэн Брюс Линколн (2003)<sup>14</sup> шашин судлаачийн дэвшүүлсэн ангиллаар ангилах боломжтой.

Монголчуудын уламжлалт шашин болох бөө мөргөл, буддын шашин нь Монголчууд төдийгүй Оросын Холбооны Улс, Хятад Улсад оршин суугаа монгол хэлт ард түмний оюун санааны амьдралд чухал байр суурь эзэлсээр байгаа билээ.

**Монголд сэргэж байгаа Бурхан шашины шинэчлэлийн асуудал** дээр гарч байгаа нэг шинэ гэж хэлж болох үйл явдал бол эрт үед монголчуудын дунд нэр нь алдаршиж дээдлэн шүтэгдэж байсан хутагт хувилгаадын хойд дүрийг тодруулах үйл ажиллагаа юм. Хутагт тодруулах ёс нь монголчуудын дунд өөрийн гэсэн үндэсний лидерүүдээ өөрсдөө тодруулах хүсэл эрмэлзэлтэй нь холбоотой үүссэн үзэгдэл боловч эрт үеэс энэ үйл явцыг Далай ламаас чиглүүлэн залж ирсэн түүхэн уламжлалаа хадгалан өнөөдөр шинээр төрж байгаа залуу лам, хутагт хувилгаадыг Төвдийн сүм хийдэд сурган боловсруулж байгааг сайшаахын зэрэгцээ шүүмжлэх хандлага аль аль нь илэрч байна. Тухайлбал, монгол лам нар Энэтхэгт суралцахад өгөх тэтгэлэг тусламжинд сэтгэл татагдах нэг хандлага байхад, уламжлалт монгол ам дамжлагын сургалт алдагдах бас нэг

<sup>13</sup> <http://vip76.mn/content/23166>

<sup>14</sup> Catherine L. Albanese 2013, *America: Religions and Religion*, pp5, University of California, Santa Barbara

тал ажиглагдаж байгааг гадна, дотоодын судлаачид шүүмжилж байна.<sup>15</sup> Бидний олж тоолсноор шинээр тодорсон хутагт, хувилгаадын тоо хорь руу дөхөж байна. Тэднээс жишээлбэл: Монголд сүүлийн үед хутагт хувилгаадыг шүтэн бишрэх үйл ажиллагааг дэмжсэн төрөл бүрийн арга хэмжээ зохион явуулж байгаагийн нэг нь хутагтыг шинээр тодруулах үйл явц юм.

“Тамгатай хутагтуудыг шинээр тодруулсан тухай мэдээ:

1. Зая бандид Лувсанпэрэнлэй судлаач Г.Жамц санаачлан 7-р Зая гэгээн Лувсанданзанпүлжинжигмэдийг тодруулах үйл ажиллагааг зохион байгуулжээ. Тэрээр Далай ламд илгээх зөвшөөрлийнх нь бичгийг төрийн захиргааны байгууллагаас гаргуулан явуулж, Жадо ренбүүчи багш “Баярту” хэмээх нэртэй хүн тодруулан Эрдэнэмандал, Хайрхан, Батцэнгэл сумдын хилийн нутаг Цоргын давааны ар гэдэг газраас тодруулжээ.

2. Говь түшээ гүний их хувилгаан Баригри Дамцагдорж хувилгаантны 4-р дүрийг тодруулах ажлыг Дундговь аймгийн нутгийн зөвлөл дэд тэргүүн Ц.Ганхүү, МБШашинтны төв Гандан тэгчилэн хийдийн дэргэдэх “Шашны их сургуулийн” доктор, Гавж Сонинбаяр болон нутгийн иргэд санаачлан 2001 оноос эхлүүлжээ. 4-р дүрийн гэгээнтэнээр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэн Үйтүмэнгийн отгон хүү 10 настай морь жилтэй Мөнхсүхийг Далай багшийн айлдвараар өргөмжиллөө. Гэгээнтэнийг гэрээс нь залж Дундговь аймгийн

Сайхан-Овоо сумын нутагт байх анхны хувилгааны барьж байгуулсан “Онгийн хийд”-ийн суудалд нь залах ёслол үйлдлээ. Гэгээнтэний сэвлэгийг нь үргээж, угаал үйлдсэний дараагаар хувцасыг нь өмсгөн сэнтийд нь залсан нь юм. 4-р дүрийн гэгээнтэн Өмнөд Энэтхэгийн нутагт байрлах Сэра дацанд 16 жил суралцаж, төгс гэгээрээд нутагтаа ирж буян номын үйлд хүчин зүтгэх юм байна.

3. Орхон аймгийн “Ялгуусан хутагтын хийд”-ийн хамба, тамгатай ширээт лам, ялгуусан хутагт 3.Гончигжавт 79 настайд нь Америкт төвтэй Олон улсын ёс заншлын холбооноос санал болгосны дагуу Монголын ёс заншил судлалын олон улсын холбоо тамгатай Х хутагтаар тодруулжээ. Тамгыг нь 2007 оны 4 сарын 14-нд Орхон аймгийн “Ялгуусан хутагтын хийд”-д гардуулсан.

4. 2013 оны 3 сарын 12-нд Ноён хутагт Данзанравжаагийн хойд дүрийг тодруулаад Энэтхэг улсад суудалд нь залаад ирсэн Монгол Улсын төлөөлөгчид албан ёсоор мэдээлэл хийв. Ноён хутагтын хойд дүрийг 400 гаруй хүнээс тодруулсан бөгөөд багаасаа ном эрдмийн мөр хөөсөн нэгэн аж. О.Ууганбаяр\Угтахбаяр нь бага байхын “Хамрын хийд”-д шавьлан, дараа нь Дашчойлон хийдэд гурван жил суусан. Мөн Энэтхэгт очиж Буддын шашны чиглэлээр долоон жил сурсан. Ирээд шашны дээд сургуульд орж, өнгөрсөн жил дипломоо гардаад буй залуу юм.

5. Ламынгэгээн Лувсанданзанжанцан: 17 настай хойд дүрийг нь тодруулж Энэтхэгт суралцуулахаар илгээсэн.

6. Чин Сүжигт Номун хан хутагт

<sup>15</sup> Lincoln, Bruce. 2003. *Holy Terrors: Thinking about Religion after September 11*. Chicago: University of Chicago Press.

Лувсанноровшарав бол Энэтхэг орноо Бардужин, Цэвээнбазар, Шийравпэрэнлэй, Бүрэн-Олзод, Гурувоба төвд орноо Лхаваандорж, Сономдагва, Сономдорж, Лодойдэмид, Баншарав, Рэнцэнбал, Ганжууржав хэмээх XII удаа тодорч Монгол оронд Лувсанноровшарав нэрээр үүнээс хойш үе уламжлан Монголд V дүр тодорсон болно. Эл гэгээний дараагийн дүр нь тодорсон байгаа ч одоохондоо нууцлагдмал байна”<sup>16</sup>.

Шинээр тодорсон хутагтууд Энэтхэгийн Гоман, Сэра зэрэг дацанд суралцаж байсан, суралцаж байгаа бөгөөд цөм Далай ламаар баталгаажуулсан учраас монголчуудын дунд хүндэтгэлтэйгээр хүлээн зөвшөөрөгдсөн, төрөлх нутаг орондоо нэгэнт нэр хүндийг олсон байна. Тэгэхлээр ирээдүйн Монголын шашины лидерүүд, сүм хийдийн удирдлагууд Далай ламын шууд нөлөөлөл дор хүмүүжиж боловсорч байгаа гэж хэлэхэд хилсдэхгүй.

Үүнтэй холбогдуулан шинээр тодорсон хутагтуудыг далай лам тодруулсан эсэх тухай мэдээллийг сонирхуулъя:

1. Жалханз хутагтын 9 дүгээр дүр Данзанчойживанчуг. Түүнийг Далай лам батламжилсан.
2. Манзушир хатагтын 7 дугаар дүр Данзанжамъяндорж. Түүнийг Далай лам 2008 онд батламжсан.
3. Зая бандидагийн 15 дугаар дүр Лувсанданзанпүлжинжигмэд. Түүнийг Далай лам 1999 онд

батламжилжээ.

4. Ламын гэгээний 8 дугаар дүр Данзанжамбалчойжишинэн. Түүнийг 2009 онд Далай лам батламжилсан.

5. Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн 9 дүгээр дүр Данзанлуvsантүдэв. Түүнийг 2013 оны 4 дүгээр сарын 28-нд Далай лам батламжилсан.

6. Егүзэр хутагтын хойд дүр Лувсанцойжин. 2014 онд Далай лам батламжилсан. Эдүгээ Энэтхэгийн Гоман дацанд суралцаж байна.

7. Зава Дамдины хойд дүр Лувсандаржаа. Энэ дүр нь эдүгээ Монгол Улс дахь Доржшүгдэн сахиусны бүлэглэлийн нөлөө бүхий хүн болохоор Далай ламаар баталгаажуулж, Монгол дахь Далай ламын бүлэглэлийнхэн түүнийг хүлээн зөвшөөрөгддөггүй юм.

Өөрнэгасуудал бол Богдтодруулахтай холбоотой асуудал байна. Энэ талаар болон ерөөс хутагт хувилгаад тодруулах ёсны тухайд, энэ нь үндэсний ухамсар, үндэсний бахархал, үндэсний лидер, үндэсний эв нэгдлийг хангах зорилгоор хийгдэж байсан үйл хэрэг мөн гэсэн<sup>17</sup> бидний дэвшүүлж буй санаа бодолтой судлаач, доктор Д.Базардоржийн дараахь үзэл баримтлал ижил байгаа юм. Тэрээр: түүхэн үйл явцаас харахад Богдын дүрүүд бол эхэндээ зөвхөн Халхын оюун санааны

<sup>16</sup> М.Гантуяа. Орчин үеийн монгол дахь буддын судлалын тойм // Японы Киото ИС-ийн Шин Буддист судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг. 2013.

<sup>17</sup> М.Гантуяа. Орчин үеийн монгол дахь буддын судлалын тойм // Отани ИС-ийн Буддын судлалын хүрээлэн дээр тавьсан илтгэл. Киото 2013, Хутагт хувилгаадыг тодруулдаг Буддын ёсны тухайд // Philosophy, Religious studies. 2014. Volume 15 (391). ISSN 2220-959X. х.147, Хутагт тодруулах монгол үндэсний үзэл санаа // Нарованчин хутагтын ойд зориулсан э.и. хурлын илтгэл. УБ 2014

удирдагчид байснаа 1911 онд Халхаар төвлөсөн Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээхэд Монгол Улсын оюун санааны их удирдагч болж, улмаар 2012 онд IX Богд манай улсын Буддын шашины тэргүүний байр сууринд албан ёсоор заларснаас хойш Монгол угсаатны эв нэгдэл, оюун санааны их удирдагчийн байр сууринд аажмаар шилжиж байгаа төлөв харагдаж байна хэмээн үзжээ.

Чухам иймээс л Богдын дараагийн дүр бол даяаршиж буй дэлхий ертөнцөд монгол угсаатны оюун санааны нэгдмэл байдал хийгээд угсаатны дархлааг бэхжүүлэхэд туйлын чухал ач холбогдолтой үнэт зүйл байх юм. Товчхондоо бол түүхэн явцад Халхын Богд Монгол угсаатны Богд болон хувирчээ. Иймээс гадны хүчний нөлөө оролцоогүйгээр Богдын хойд дүрийг монгол хүнээр тодруулан батламжилснаар үндэсний аюулгүй байдлыг бататгасан олон боломжууд гарч ирнэ гэж үзэж байна. Тухайлбал: **Нэгдүгээрт**, гадаад харилцааны таатай орчин улам баталгаажна. **Хоёрдугаарт**, өөрийн онцлогтой бие даасан шашин, бусдаас хараат бус шашины тэргүүнтэй байх гэсэн монголчуудын түүхэн хүсэл хангагдана. **Гуравдугаарт**, монголчууд оюун санааны нэгдмэл үнэт зүйлтэй болж, үндэстний дархлаа батжина. **Дөрөвдүгээрт**, хилийн чинадад байх монгол угсаатныг оюун санааных нь хувьд нэгтгэх бодит хүчин зүйл буй болно. **Тавдугаарт**, Богдын дараа дараагийн дүрүүд гадны хүчний оролцоогүйгээр тодрох түүхэн орчин бүрдэнэ. **Зургаадугаарт**, манай улсын Буддын шашины удирдлагын доторх үзэл бодол, байр суурийн үндсэн зөрөө

арилж, нийт сүсэгтэн монголчуудынхаа дэмжлэгийг хүлээсэн монгол угсаатны нэгдмэл хүчирхэг шашин-соёлын ижилслийг бүрдүүлнэ. **Долдугаарт**, монголчуудын оюун санаа итгэл бишрэлийн нэгдмэл үнэт зүйл бий болсноор Утай, Гүмбум, Итгэлт хамба руу чиглэсэн мухар сүсэг бишрэлийн урсгал зогсож, хэтдээ дотоод гадаадаас Богд руу чиглэсэн шашин-соёлын шинэ орчин, түүнийг тойрсон эдийн засаг, нийгэм соёлын шинэ нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.<sup>18</sup>

Монголчуудын XXI зууны шашин-соёлын нэг онцлог байдал нь уламжлалт бөө мөргөл, буддын шашинаас гадна **олон янзын шашин** манай ард түмний дунд дэлгэрээд зогсохгүй тэдгээр шашинууд нь хоорондоо олон янзын урсгал чиглэл болон салж байгааг олон улсын судалгааны төвийн 2014 оны судалгаанд дурджээ<sup>19</sup>. Энэхүү судалгааны үр дүнг харвал шашины олон урьгалч байдлаар Хятад улс 7.3, Монгол улс 6.5, ОХУ улс 4.9 индекстэй байна. Монгол хэлт ард түмний дунд 1990 оноос хойш олон янзын шашин дэлгэрэх болсон нь дараахи гол шалтгаануудтай холбоотой. Үүнд:

- Бүс нутагт гарсан улс төр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтүүд
- Бүс нутагт ноёрхож байсан улс төр, нийгмийн хуучин үзэл суртал халагдаж, түүний оронд шинэ үзэл сурталын хоосон орон зай бий болж, шашины үзэл суртал

<sup>18</sup> Олон улсын харилцааны хүрээлэнгийн ЭШАА., доктор / Ph.D/Д.Базардорж. Богдын дараагийн дүрийг тодруулах асуудалд. Түүхэн нөхцөл ба боломж, сорилт

<sup>19</sup> <http://www.pewforum.org/2014/04/04/religious-diversity-index-scores-by-country/>

ноёлох нөхцөл бүрдсэн.<sup>20</sup>

- Дэлхийн олон улс орнуудтай Монгол улс гадаад харилцаа, соёлын хамтын ажиллагаагаа эрчимтэй хөгжүүлэх болсон

- Чөлөөт зах зээлийн үед хүн амын зорчих хөдөлгөөн ихсэж, гадаад, дотоодын иргэд бүс нутагт чөлөөтэй аялан зорчиж гадаадын соёл, шашин зан заншилтай танилцах болсон

- Гадаадын шашны байгууллагууд үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулах болсон

- Монголд орчин үеийн мэдээллийн техник, технологийн хөгжил нэвтэрч иргэд интернэт, е-мэйл, олон нийтийн мэдээллийг чөлөөтэй авах болсонтой холбоотой.

Хятад, ОХУ-ын хувьд шашины олон янз байдлыг хүлээн зөвшөөрдөг ч гэсэн төр, шашины харилцааны зарим асуудлыг зохицуулахад эрдэмтэн судлаачдын судлагаан дээр тулгуурлан тусгай бодлого боловсруулдаг институт ажиллаж, төрөөс улс орны эв нэгдэл, эрх ашиг, үндэсний аюулгүй байдалтай холбоотой шашины асуудлыг зохицуулахад зөвлөх үүрэг гүйцэтгэж иржээ. Хятад улсын Шашины асуудал хариуцсан захиргаа нь Хятадын шашины судлагааны төв болон Хятадын эх оронч шашины байгууллагуудтайгаа хамтран ажилладаг байна.

Хятадын эх оронч шашины байгууллагууд, тэр дундаа Хятадын эх оронч Протестант сүм нь “Турван

Өөрсдөө” бодлогыг баримтлан: 1-рт, шашины эрх мэдэл, засаг захиргаагаа хятад хүмүүс гадаадын шашины байгууллагын нөлөөнөөс ангид өөрсдөө удирдах, 2-рт, сүм нь эдийн засгийн хувьд гадаадаас тусламж авахгүй өөрсдийгөө дэмжих, 3-рт, шашины номлолоо хятад хүмүүс өөрсдөө удирдан явуулах бодлого хэрэгжүүлж, сүм цуглааны дагалдагчиддаа улс орныхоо түүх, хэл, соёл, ёс заншил, уламжлалаа дээдлэн хүндэтгэдэг, эх оронч хятад иргэн болгоход үйл ажиллагаагаа чиглүүлдэг байна.

ОХУ-ын “Всероссийский центр изучения общественного мнения” (Нийтийн сэтгэл санааг судлах Бүх Оросын төв) (ВЦИОМ) төвийн 2015 оны ОХУ дахь шашины нөхцөл байдлын талаар судалгаанд<sup>21</sup> оролцогчдын 50% нь Оросын Үнэн алдартны шашин нь Оросын түүх соёл, нийгэм, хувь хүний хөгжил цэцэглэлтэнд нөлөөтэй тул ОХУ-ын ерөнхийлөгчөөс дэмжлэг авах ёстой гэж үзжээ. Мөн ОХУ-ын буриад, халимагийн ард түмний соёл, уламжлал, түүхтэй холбоотой буддын шашиныг төрөөс хүндэтгэн үздэг байна.

Манай хоёр хөршийн төрөөс шашины талаар авч явуулж байгаа бодлого нь улс орныхоо эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлыг харгалзан, уламжлалт шашинаа дэмжих бодлого баримтлан, уламжлалт бус шашиныг ялгаварлан гадуурхах бодлого явуулж байгаа талаар барууны хүний эрхийн байгууллагууд, судлаачид судлагаандаа дурдсан байдаг. Олон улсын судалгааны Певфорум байгууллагын 2010 оны судалгаанд Хятадын төрөөс шашины

<sup>20</sup> Michael Stausberg, 2009, *Contemporary theories of Religion, a critical companion, /Religious economies and rational choice: Rodney Stark and Roger Finke/by Gregory D. Alles, Routledge, USA*

<sup>21</sup> <http://wciom.ru/index.php?id=236&uid=115329>

байгууллагуудад тавих хяналт, дарамт шахалт 9.1 индекс байсан бол ОХУ-ын төрөөс шашины байгууллагуудад тавих хяналт, дарамт шахалт индекс нь 7.4 байна. Харин Монгол улсын хувьд төрөөс шашины байгууллагуудад тавих хяналт, дарамт шахалтын бодлого нь харьцангуй аядуу зөөлөн буюу 2.4 индекс оноотой байна.

Монгол, Хятад, ОХУ-ын ард түмний шашин шүтлэгт хандах нэгэн өвөрмөц онцлог нь шашин шүтлэггүй хүмүүсийн тоо дэлхийн бусад АНУ, Энэтхэг, Ойрхи дорнодын улс үндэстнүүдээс харьцангуй их байдагт оршино. Жишээ нь: Монгол улсад хүн амын 38.6%, ОХУ-д 16.2% (үүнд, Оросын үнэн алдартны шашинтан гэж санал өгсөн 73.3% иргэдийн 55% нь сүмийн мөргөл, үйл ажиллагаанд байнга оролцоггүй гэжээ), Хятад улсад 52.2% нь шашин шүтлэггүй гэсэн судлагааны дүн<sup>22</sup> байна.

Өнөөдөр дэлхийн улс орон бүр шашины эрх чөлөөний асуудалд хүндэтгэлтэй хандаж, улс орны эв нэгдэл, үндэсний аюулгүй байдалтай холбоотой шашины асуудалд болгоомжтой хандах болжээ. Даяарчлалын эрин үед бүс нутгийн геополитикийн асуудлаас дутуугүй тулгамдсан асуудал нь бүс нутгийн шашины асуудал болж байгааг улс төр судлаач, дипломатчид болон шашин судлаачид анхааруулах болжээ. Ардчилалын эх орон гэгддэг АНУ-д мөн Олон улсын шашины эрх чөлөөний асуудалд анхаарал хандуулдаг Америкийн Нэгдсэн улсын хороо нь /USCIRF/<sup>23</sup> жил

бүр улс орнуудад шашины эрх чөлөө хэрхэн хөндөгдөж байгаа талаар мэдээлэл гаргаж АНУ-ын ерөнхийлөгч, конгресст шашины асуудлаар зөвлөгөө өгдөг байна. Америкийн сүм хийд шашины байгууллагуудын гол үйл ажиллагаа нь нийгэмд хандсан сайн үйлсээс гадна өөрсдийн дагалдагчдаа зөв америк хүн болгон төлөвшүүлж, нийгмийн сайн сайхны төлөө үүрэг хариуцлага хүлээх ухамсар, ёс суртахуунтай иргэн болгоход анхаарлаа хандуулдаг байна. Энэхүү үйл ажиллагааг нь тухайн улсын төр, олон нийтийн зүгээс дэмжиж иржээ. Энэ мэтчилэн дэлхийн олон улс орны төр засгийн болон иргэний байгууллагууд нь шашин соёлын асуудалд хүндэтгэлтэй хандаж, бүс нутаг, эх орондоо энх тайван байдал тогтоохын тулд шашины хоорондын ойлголцол, зөвшилцлийг бий болгохыг зорих болжээ.

## ДҮГНЭЛТ

Өнөөдөр монголчууд нүүдлийн соёл иргэншлийнхээ язгуур шинжүүдийг бататган баяжуулж, дэлгэрүүлэх, монгол иргэншил, оюуны соёл, зан заншлынхаа үнэ цэнэтэй, дэвшилттэй бүхнийг өвлөн авах, монгол хүний онгон байгальдаа зохицон аж төрөх эрдэм чадвар билиг ухааныг хадгалж үлдээх чухал зорилттой тулгарч байна.

Монголчууд нүүдэлчин амьдралаас суурин соёл иргэншилд шилжихийн хэрээр байгальтай харьцах түүхэн уламжлал алдагдаж, уламжлалт шашин-соёлоосоо холдохын хэрээр хатуу ширүүн зан авираар солигдох болсоныг судлаачид

<sup>22</sup> [http://www.globalreligiousfutures.org/countries/china/religious-demography/#/?affiliations\\_religion\\_id=0&affiliations\\_year=2010](http://www.globalreligiousfutures.org/countries/china/religious-demography/#/?affiliations_religion_id=0&affiliations_year=2010)

<sup>23</sup> [http://www.uscif.gov/about-uscif/who-we-are/what-we-do](http://www.uscifr.gov/about-uscif/who-we-are/what-we-do)

болон олон нийтийн зүгээс шүүмжлэх боллоо.

Энэ цаг үед монголчуудын уламжлалт үзэл санаа, ертөнцийг үзэх үзэл, боловсрол хүмүүжил, сургаал захиасыг эргэн санаж, нөхөн дэлгэрүүлэх нь өнөө цагийн зорилт болно.

Өнөөгийн ардчилалын эрин үед Монголчуудын шашинд хандах үзэл, хандлагад өөрчлөлт оруулах, олон нийтийн шашин соёлын тухай боловсролыг дээшлүүлэх, шашинд хүндэтгэл, болгоомжтой хандан шашны байгаль хамгаалах сургааль номлол, зан үйлийг зүй зохистой дэмжиж одоо үед тулгамдаад буй байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд олон янзын шашны байгууллагуудын үйл ажиллагааг нэг зүгт чиглүүлэх шаардлага тулгараад байгааг анхаарах хэрэгтэй.

Даяаршилын эрин 21-р зуунд хүний үндсэн эрх болсон шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг үндсэн хуулиараа тунхаглаж өгсөнөөр олон янзын шашин монголчуудын дунд байр сууриа бэхжүүлэхээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ үед төрөөс шашинд хүндэтгэлтэй хандаж, улс эрх орны эрх ашиг, үндэсний аюулгүй байдалтай холбоотой шашины асуудалд болгоомжтой хандахын зэрэгцээ төр, сүм хийдийн харилцааны хуулийг боловсронгуй болгож, төрөөс шашины асуудалд хандахдаа эрдэмтэн судлаачдын судлагаанд тулгуурлан бодлого боловруулж, хэрэгжүүлдэг төв байгуулах цаг нэгэнт болсоныг илтгэлийнхээ төгсгөлд шийдвэрлэх асуудал болгон дэвшүүлж байна.

## НОМ ЗҮЙ

1. М.Гантуяа. Өнөөгийн монголчуудын шашин шүтлэгийн төлөв байдал, чиг хандлага //Философи, шашин судлал. 2015. Volume 17 (434). ISSN 2220-959X. х.132
2. Б.Гантөмөр, М.Гантуяа. Байгаль экологийн бодлого ба рашаан усны талаархи монгол цээр ёс //Философи, эрхзүйн боловсрол. МУБИС, ТНУС-ийн э.ш.бичиг. 2014/7.
3. С.Цэдэндамба. Монголын сүм хийдийн түүхэн товчоон, УБ, 2009, 16-р хуудас
4. ШУА, Түүхийн хүрээлэн, Монгол улсын түүх, УБ, 2004, 5-р боть,
5. Glein Mullin. Олон улсын Төвд судлалын XIII их хурал дээр тавьсан илтгэл, 2013, УБ
6. Монголын Эвангелийн Эвсэл. “Таж буруу урсгалууд” танилцуулга, 2013, УБ
7. Catherine L. Albanese 2013, America: Religions and Religion, pp5, University of California, Santa Barbara
8. Lincoln, Bruce. 2003. Holy Terrors: Thinking about Religion after September 11. Chicago: University of Chicago Press.
9. Олон улсын харилцааны хүрээлэнгийн ЭШАА., доктор /Ph.D/ Д.Базардорж. Богдын дараагийн дүрийг тодруулах асуудалд. Түүхэн нөхцөл ба боломж, сорилт
10. Michael Stausberg, 2009, Contemporary theories of Religion, a critical companion, /Religious economies and rational choice: Rodney Stark and Roger

- 
- |                                              |                                                                                           |
|----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|
| Finke/by Gregory D. Alles, Routledge,<br>USA | <a href="#"><u>demography#/?affiliations_religion_id=0&amp;affiliations_year=2010</u></a> |
|----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|
11. [http://www.pewforum.org/2014/04/04/religious-diversity-index-scores-by-country/](#)
  12. [http://wciom.ru/index.php?id=236&uid=115329](#)
  13. [http://www.globalreligiousfutures.org/countries/china/religious](#)
  14. [http://www.uscirf.gov/about-uscirf/who-we-arewhat-we-do](#)
  15. [https://tuv.nso.mn/uploads/users/4/files/XAOCT%20uls.pdf](#)
  16. [https://en.wikipedia.org/wiki/Glenn\\_H.\\_Mullin](#)
  17. [http://www.iats.info/panels-and-sessions/](#)

### ABSTRACT

The life style, skill, ideology and religion of Mongolians signify special feature of nomadic civilization. The chronology of their cultural and religious aspects divided by the following three historical periods: the shamanism and tengerism was influential among Mongolians in the ancient and early medieval period, the Buddhism was popular in the medieval period and late medieval period.

Buddhism, Christianity, Islam, shamanism and the new religious movements spread among the native Mongolian speakers in the modern globalization era.

We proposed the necessity to study the change and reformation of culture and religion of Mongolians in this paper. The culture and religion is the key factor for preserving and protecting environment, developing cultural integrity, developing some economic field in the area.